

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

**“ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН ТӨВ” ОНӨТҮГ ДАХЬ СЕРВЕРҮҮД,
ПРОГРАММ ХАНГАМЖ, СҮЛЖЭЭ БОЛОН ТҮҮНИЙ ХАМГААЛАЛТЫН БОЛОН
БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН АРЧЛАЛТ ХАМГААЛАЛТЫГ ХИЙХ
АЖЛЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

Ерөнхий зүйл: “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын төвийн байр буюу серверийн өрөөнд байрлах нийт тоног төхөөрөмжүүдийн арчлалт, хамгаалалтын хэвийн найдвартай ажиллагааг хариуцах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмтэл, халдлага гарсан үед шуурхай арга хэмжээ авах, программ хангамжид гарсан гэмтэл саатлыг шуурхай засварлах, шаардлагатай тохиолдолд нэмэлт хөгжүүлэлт хийх, тохируулах.

Төрийн мэдээллийн нэгдсэн системүүдтэй холбогдож ажиллах Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Үндэсний дата төв, Авто тээврийн үндэсний төвтэй мэдээлэл солилцох, гэрлэн дохиог төвөөс удирдах зөрчил торгуулийн программ хангамж, өгөгдлийн сан болон эдгээрийг холбосон сүлжээ, серверийн засвар арчлалтыг хариуцан ажиллах.

1. “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-т байрлах дараах серверүүдийн хэвийн ажиллагааг хангах, эвдэрч гэмтсэн тохиолдолд түргэн шуурхай засварлаж ажиллана. Үүнд: Серверүүдийн сүлжээ, техник хангамжийн хэвийн ажиллах, виртуал серверийн тохиргоо, суурилуулалт, засвар, эвдэрч болзошгүй хэсгүүдийг шуурхай засварлах арга хэмжээ авна. Төрөл бүрийн үйлдлийн системүүдтэй нийт 22 серверийн арчлалт хамгаалалтыг хариуцаж ажиллах.

2. “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ дээр байрлах сүлжээний 9 нэр төрлийн 250 төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж эвдэрч гэмтсэн тохиолдолд түргэн шуурхай засварлаж, төвийн үйл ажиллагааг тогтвортой ханган ажиллах.

3. “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ дээр байрлах дараах программ хангамжуудын хэвийн найдвартай ажиллагааг хангаж эвдэрч гэмтсэн тохиолдолд түргэн шуурхай засварлаж шаардлагатай хөгжүүлэлтүүдийг цаг тухайд нь бүрэн хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь дараах хэл дээр бичигдсэн программуудын хөгжүүлэлтийг хийх чадвартай байна.

C++ Builder /Borland c++ builder/, Java /netbeans/, Php, Python гэх мэт

№	Программ хангамжууд
1	Торгуулийн нэгдсэн системийн программ
2	Камерын хяналт, удирдлагын программ
3	Гэрэл дохио удирдах программ

4	Замын ачааллын мэдээллийн боловсруулах программ
5	Зөрчлийн программууд
6	E-police зөрчлийн программ
7	Төвийн үйл ажиллагаа мэдээллийн веб хуудас
8	Авто замын хөдөлгөөний ачааллыг шууд харуулах веб хуудас
9	Бусад системүүдийн интеграци, өгөгдлийн сан

4. "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-т байрлах дараах мэдээллийн сангуудын хэвийн найдвартай ажиллагааг хангаж эвдэрч гэмтсэн тохиолдолд түргэн шуурхай засварлаж шаардлагатай хөгжүүлэлтийг цаг тухайд нь хийж гүйцэтгэнэ.

№	Мэдээллийн сангууд
1	Замын хөдөлгөөний удирдлагын төвийн гэрлэн дохио, замын ачааллын мэдээ, төхөөрөмжүүдийн ажиллагааны мэдээ зэргүүдийн нэгдсэн сан
2	Зөрчлийн мэдээллийн сан
3	Торгуулийн нэгдсэн системийн мэдээллийн сан
4	Бусад мэдээллийн сангууд

5. "Замын хөдөлгөөний удирдлагын төв" ОНӨТҮГ-т байрлах дараах тоног төхөөрөмжүүдийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж эвдэрч гэмтсэн тохиолдолд түргэн шуурхай засварлаж ажиллана.

Бусад тоног төхөөрөмжүүд		
№	Нэрс	Тоо ширхэг
1	LCD 32 инчийн хяналтын дэлгэц	30
2	LED 55 инчийн хяналтын дэлгэц	20
3	Хөргөлтийн төхөөрөмж	6
4	Тог баригч төхөөрөмж 380в /UPS/	1

6. Сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн лицензийг суулгах тохиргоо хийх.

7. Дараах сэлбэгүүдийг нийлүүлж суурилуулна.

№	Нийлүүлэх болон суурилуулах сэлбэгийн жагсаалт	Тоо ширхэг
1	SAS SSD 1TB, speed 12gbps	20

8. Гүйцэтгэгч нь гүйцэтгэлээр санхүүжих ба засвар арчлалтын ажлын явцыг фото зургаар заавал баталгуулсан байх ба фото зургаар баримтжуулаагүй ажлыг хүлээн авахгүй болно.

Хянасан:

Замын хөгжлийн газрын засвар
арчлалтын хяналтын хэлтсийн дарга


О.Энхбаатар

"Замын хөдөлгөөний удирдлагын төв"
ОНӨТҮГ-ын захирал


Ч.Хувьзаяа

Боловсруулсан:

Мэдээллийн технологи, техник ашиглалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн


Г.Алтаншагай